

**АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

2021.06.15

Зуунмод

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжилт
1.Ажиллах нөхцлийг сайжруулах чиглэлээр			
1	МЭТасгийн албан хаагчдыг компьютер, тоног төхөөрөмжөөр байгууллагын шаттайгаар үе шаттайгаар ханга, Ажлын байрны засвар хийх,	2,3-р улиралд	Эхний хагас жилийн байдлаар байгууллагад 3 албан хаагчийг 5,379,000 төгрөгийн компьютер, 484,000 төгрөгийн принтерээр хангаж ажилласан. Мөн байгууллагын конторын барилгын гадна ханыг ард талд 130,000 төгрөгийн материалаар засвар хийсэн.
2	Ажилчдыг /Ковид/-ын халдвараас урьдчилан сэргийлж амны хаалт, дархлаажуулах хүнсний бүтээгдэхүүн олгох, цайны цагаар өдрийн хоолоор үйлчлэх	2.3-р улиралд	Коронавирусын халдвараас сэргийлж албан хаагч тус бүрт 50 ширхэг амны хаалт, дархлаа дэмжиж чацаргана, аньсны шүүс болон витамин-D3, витамин C1000, амин дэмүүдийг олгосон бөгөөд өрөөнүүдэд гар ариутгагч, халуун хэмжигч байрлуулсан
3	Албан хаагчдыг интернэтийн болон компьютерийн дотоод сүлжээнд бүрэн хамруулж мэдээлэл авах боломжоор хангах	Жилдээ	МЭХЦэгийн албан хаагчдад Юнителийн гэр интернэтийн төхөөрөмж суурилж дотоод сүлжээ болон МЭНС-д ажиллах боломжийг бүрэн хангасан. 8 сумын Мал эмнэлгийн тасгийн интернэтийн сунгалтыг хийж сүлжээ хэвийн ажиллаж нөхцлийг бүрдүүлсэн.
4	Лабораторийн албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулж, тоног төхөөрөмж нэмэгдүүлэх, хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүнээр хангах.	Жилдээ	МЭЛабораторийн үүдний өрөөний шалны хулдаасыг сольж, албан хаагчдад шинжилгээ хийхэд шаардлагатай хэрэглэх бээлий, малгай олгож хор саармагжуулах
5	МЭХЦэгийн болон Мал эмнэлгийн тасгийн албан хаагчдын шаардлагатай тоног төхөөрөмж, бичгийн хэрэгсэлээр хангах	Жилдээ	Лүн МЭХЦэгт 74650 төгрөгийн бичиг хэргийн материал, 82900 төгрөгийн амны хаалт, аж ахуйн материал, 23100 төгрөгийн барилгын засварын материал тус бүр олгосон. Мал эмнэлгийн тасгийн албан хаагчдад 600,000 төгрөгийн шатахуун,

			602,450 төгрөгийн бичиг хэргийн материалаар хангаж ажилласан.
2. Нийгмийн баталгааг хангах чиглэлээр			
6	Ажилтан, албан хаагчдад цалингийн зээл авахад нь дэмжлэг үзүүлэх	Жилдээ	МЭГ-н болон МЭТ-ийн ... албан хаагчдад Банк болон ББСБ-с зээл авахад нь цалингийн тодорхойлолт гарган өгсөн.
7	Өндөр насны тэтгэвэрт гарах албан хаагчдад олгох нэг удаагийн тусламжийн санхүүжилтийг төсөвт суулгах.	3-р улиралд	Батсүмбэр сумын МЭТасгийн Н.Мөнхцэцэг, жижүүр Ж.Даваадорж нарын хүсэлтийг хүлээн авч өндөр насны тэтгэвэрт гарах албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг 2022 оны төсөвт суллуулахаар саналыг МЭЕГазарт хүргүүлсэн.
8	Албан хаагчдад хоол унааны мөнгийг зохих хувиар тооцож сар бүр олгох	жилдээ	Байгууллагын нийт албан хаагчдад хоол, унааны мөнгийг өдрийн 4000 төгрөгөөр бодож сар бүрийн цалинтай хамт олгосон.
9	Ээлжийн амралтыг газрын даргын баталсан хуваарийн дагуу биеэр эдлүүлэх	жилдээ	Газар болон МЭТ-ийн албан хаагчдын саналыг авч нэгтгэн Газрын даргын 2021оны А/06 дугаар тушаалаар албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг батлан албан хаагчдын ээжлийн амралтаа биеэр эдлэх нөхцлийг бүрдүүлсэн бөгөөд эхний хагас жилийн байдлаар 4албан хаагч ээлжийн амралтаа эдэлж эхэлсэн.
10	Улирал, жилийн ажлын үр дүнгээр урамшуулал олгох, тэмдэглэлт ойн баяр ёслолын үеэр ажилчдыг шагнаж урамжуулах, бусад шагналд тодорхойлж, холбогдох газруудад уламжлах.	жилдээ	1 дүгээр улирлын ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлж, хангалттай үнэлэгдсэн албан хаагчдад 10-30% урамшуулал олгож ажилласан. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж хагас жилээр ямар нэгэн шагнал урамшуулал олгоогүй байна.
11	Албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, давтан сургах, дотоод гадаад сургалтанд хамрагдахад дэмжлэг үзүүлэх	жилдээ	Удирдлагын Академи ба Төрийн албаны зөвлөлийн хамтарсан 37/33 тоот тушаалын 3.2-т заасны дагуу албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтад зайн хэлбэрээр 5 албан хаагчийг хамруулсан.
12	Гэр бүлийн өдөрт зориулан албан хаагчдад цалинтай чөлөө олгох, арга хэмжээ зохион байгуулах	жилдээ	Коронавируст халдвараас урьдчилан сэргийлж байгууллагын 0-12 настай эмэгтэй албан хаагчдад гэрээсээ ажиллах нөхцлийг бүрдүүлсэн.
13	Албан хаагчдын бие бялдар, чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх зорилгоор хуваарийн дагуу	жилдээ	Байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийн дэмжих, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх үүднээс ГБХЗХГ-тай гэрээ байгуулан

	зааланд тоглох /Волейбол, теннис/явган аялал зохион байгуулах		спорт зааланд тоглох гэрээ байгуулсан боловч коронавируст халдварын нөхцөл байдал, бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдалд байгаа хугацаанд спорт зааланд тоглож чадаагүй.
14	Албан хаагчдад байгууллагын дотоод журамд заасны дагуу тусламж, тэтгэмж үзүүлэх.	жилдээ	Нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд 1 албан хаагчид 680,000 төгрөг, МЭТ-н тархвар зүйч өвчний улмаас нас барсан тул ар гэрт нь 3 сарын үндсэн цалинтай тэнцэх буцалтгүй тусламж олгож, газрын 8 албан хаагчдад дотоод журамд заасны дагуу 2-5 хоногийн цалинтай чөлөө олгож ажиллалаа.